



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/359

Арвайхээр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.4 дэх заалт, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” 166 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ хоршоо-хөдөлгөөн”-ий хүрээнд хууль тогтоомжийг аймгийн малчин өрхүүдэд сурталчлан таниулах, мэдээлэл, сургалт хийх, мал аж ахуйн чиглэлийн хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах, зөвлөн туслах багийг орон нутагт ажиллахад үйл ажиллагаанд нь хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлж ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай

2. “Шинэ хоршоо-хөдөлгөөн”-ийг зохион байгуулсан талаар болон сумдын малчин өрхүүдэд мэдээлэл өгөх, сургалт хийх, мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодын үйл ажиллагааг идэвхжүүлэх, чадавхжуулах чиглэлээр явуулсан арга хэмжээний тайланг нэгтгэн гаргаж, танилцуулан 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг Ажлын хэсэг (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




И.ДОРЖСҮРЭН

6224 11 0736

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар
сарын 06-ны өдрийн 739 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Тэгшбаяр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Гишүүд:

Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ц.Ариунаа (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)

Б.Цэнгэл (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)

Д.Батсуурь (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын албаны дарга)

Сумдын Засаг дарга нар

-оОо-